

Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл – 2-р шат
Хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төв,
Түр хамгаалах байруудын үйлчилгээг өртгөтгөх, сайжруулах
Төсөл сонгон шалгаруулах урилга

2021 оны 4 сар

Монгол дахь Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сангаас (НҮБХАС) Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ), гэр бүлийн хүчирхийллийн (ГБХ) хохирогчдод үйлчилгээ үзүүлж буй Нэг цэгийн үйлчилгээний төв (НЦҮТ), Түр хамгаалах байруудыг (ТХБ) төслийн шалгаруулалтанд оролцохыг урьж байна. Шалгарсан төслүүд Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төслийн (ЖСХТТ) 2-р шатны хэрэгжилтийн хугацаанд төслийн зүгээс хэрэгжүүлэгч байгууллагуудаар дамжуулан техник аргагүйн болон санхүүгийн тусламжийг авах юм.

А. Үндэслэл

ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үндэстний чадавхийг бэхжүүлэх салбар дундын олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой 4 жилийн санаачлага болох Жендэрт Суурилсан Хүчирхийлэлтэй Тэмцэх нь төслийг (ЖСХТТ) 2016 оноос НҮБХАС, Монгол улсын Засгийн газар, Швейцарын хөгжлийн агентлаг хамтран хэрэгжүүлсэн. ЖСХТТ-ийн 1-р шат ЖСХ-ийн бодит байдал ямар байгааг тодорхойлох тоо мэдээллийг бий болгож; шийдвэр гаргагчид болон олон нийтийн ЖСХ-ийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлэн, хүчирхийллийг таслан зогсоох яаралтай арга хэмжээ авах шаардлагатайг ойлгуулж; хүчирхийллийн даван туулагчдыг хамгаалж, хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага тооцож, хүчирхийллийг дахин давтагдахаас урт хугацаанд сэргийлэхэд чиглэсэн салбар хоорондын олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх гэсэн 3 үндсэн чиглэлээр амжилттай хэрэгжсэн.

Төслийн 1-р шатны хүрсэн үр дүнд суурилсан төслийн 2-р шат нь урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үндэстний чадавхийг үргэлжлүүлэн бэхжүүлэх замаар Монгол улсад ЖСХ/ГБХ-ийн тархалтыг бууруулахыг зорьж байна. Энэхүү үр дүнд хүрэхийн тулд төслийн 2-р шат нь (1) даван туулагчдыг хамгаалж, хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага тооцох механизм болон ЖСХ/ГБХ-ийн тоо мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, түгээх тогтолцоог институтчилэх; (2) хүн амын зорилтот бүлгүүдийг хамруулсан урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга зүйн загварыг бий болгох замаар жендэрийн тэгш байдлын зарчимд суурилсан нийгмийн хэм хэмжээг ойлгож, дагаж мөрддөг зан үйлийг хэвшүүлэх гэсэн 2 зорилгын хүрээнд хэрэгжих юм.

Дээрх зорилгуудад хүрэхийн тулд хийгдэх ажлуудын нэг нь 5 аймаг, 1 дүүргийн нийт 6 НЦҮТ болон ТХБ-ыг сонгон шалгаруулж дэмжлэг үзүүлэх юм. Шалгарсан төвүүд төслөөс техник арга зүйн болон санхүүгийн дэмжлэг авах ба үйл ажиллагаа болон үйлчилгээгээ илүү өргөжүүлж, даван туулагчдыг хэвийн амьдралаа цаашид бие даан үргэлжлүүлэхэд дэмжлэг үзүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлэх юм. Мөн түүнчлэн сонгогдсон газрууд НҮБХАС-ийн мэргэжилтнүүд болон зөвлөхүүдийн дэмжлэгтэйгээр зан үйл өөрчлөх цогц загварыг турших нэмэлт дэмжлэг авах болно.

ЖСХТТ-ийн 2-р шат нь 2020-2023 онд хэрэгжинэ. Тиймээс шалгарсан төвүүд 2021-2023 оны хооронд төслийн зүгээс дэмжлэг аван хамтран ажиллах юм.

В. Төслийн түшиц газрууд ба Хүлээгдэж буй үр дүн

Энэхүү төслийн уралдаанаар ЖСХТТ-ийн 2 дахь шатны хүрээнд үйлчилгээ болон үйл ажиллагаагаа өргөтгөх хамгийн үр дүнтэй төслийг боловсруулсан НЦҮТ болон түр хамгаалах байрыг шалгаруулах бөгөөд шалгарсан НЦҮТ болон ТХБ нь төслийн зүгээс үзүүлэх мэргэжлийн болон санхүүгийн дэмжлэгийг төслийн хэрэгжүүлэгч байгууллагуудаар дамжуулан авах замаар дараах үр дүнд хүрэх зорилтыг хэрэгжүүлэх юм. Үүнд:

1. Хүчирхийллийн даван туулагчид НЦҮТ/ТХБ-д үйлчлүүлэх явцдаа цаашид нийгмийн амьдралд орж, амьдралаа хэвийн үргэлжлүүлэх, цаашлаад дахин хүчирхийллийн хохирогч болохоос өөрийгөө болон хайртай хүмүүсээ хамгаалах ур чадвар эзэмшиж, өөртөө бүрэн итгэлтэй болоход туслах чиглэлээр **ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮЙЛЧИЛГЭЭГЭЭ ӨРГӨЖҮҮЛЭХ**. Үүнд: эдийн засгийн боломжтой болоход туслах үйл ажиллагаа (жишээ нь: амжиргаагаа дээшлүүлэх, бичил санхүүжилтийн хөтөлбөрүүд гэх мэт), нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөө дэмжлэгийг урт хугацаанд үзүүлэх замаар өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, хүний эрхийн болон бусад чухал ойлголтуудын талаар сургалт орох, болон амьдралаа цааш хэвийн үргэлжүүлэхэд туслах ур чадваруудыг эзэмшихэд шаардлагатай үйлчилгээг авах, холбон зуучлах гэх мэт үйл ажиллагаанууд орно. Төвийн ажилтнууд шинэ хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд хэрэг болохуйц чадавхи бэхжүүлэх сургалтын үйл ажиллагааг мөн төсөлдөө оруулж болно.
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бусад эмзэг бүлгийн хүмүүст ээлтэй, хүртээмжтэй болгохын тулд **БАЙРНЫ НӨХЦЛИЙГ САЙЖРУУЛАХ**. НЦҮТ/ТХБ-ны байрны нөхцлийг сайжруулах төлөвлөгөө нь одоо үйлчлүүлж буй болон урьд нь үйлчлүүлж байсан хүмүүсийн, мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бусад эмзэг бүлгийн иргэдийн хэрэгцээ, санал дээр тулгуурласан болохыг нотлон харуулах ёстой.

Төслийн шалгаруулалтанд оролцогч нь Төслийн Саналаа хавсралтад буй Өргөдлийн маягтын дагуу бөглөж ирүүлэх бөгөөд үйл ажиллагаа өргөжүүлэх, байрны нөхцлийг сайжруулах нарийвчилсан төлөвлөгөөг оруулсан байна.

НЦҮТ/ТХБ-ын үйл ажиллагаа, үйлчилгээг өргөжүүлж сайжруулах төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээс гадна тухайн төв байгаа орон нутаг, НҮБХАС-ийн мэргэжилтнүүд болон зөвлөхүүдтэй хамтран зан үйл өөрчлөх цогц загварыг хэрэгжүүлэхэд оролцон, энэ чиглэлээр нэмэлт дэмжлэг авах юм. Иймээс Өргөдлийн маягт дээр НЦҮТ/ТХБ-тай хамтран ажиллах орон нутгийн байгууллага, иргэдийн талаарх нэмэлт мэдээллийг оруулах хэрэгтэй бөгөөд сонгон шалгаруулалтын үед харгалзан үзэх болно.

С. Тавигдах шаардлага

Доорх шаардлагыг хангасан Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа **гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, даван туулагч болсон бүх нас, хүйсний хүмүүст** үйлчилгээ үзүүлдэг аль ч НЦҮТ¹ эсвэл ТХБ² энэхүү уралдаанд оролцон өргөдлөө ирүүлэх боломжтой.

- Өргөдөл ирүүлэх үед дор хаяж 6 сар үйл ажиллагаа тасралтгүй явуулсан байх
- Хууль ёсны статустай, холбогдох газарт бүртгэлтэй
- Орон нутгийн засаг захиргаа эсвэл төрийн бус байгууллагын харьяа үйл ажиллагаа явуулдаг байх
- Ирүүлсэн төслийг хэрэгжүүлэх хангалттай тооны, мэргэжлийн боловсон хүчинтэй байх
- Ирүүлсэн төслийн хэрэгжилтэнд зуучлагчын үүрэгтэйгээр бус харин төслийн төлөвлөлт, удирдлага зохион байгуулалт, хэрэгжилт, явцын хяналт, тайлагналт зэргийг шууд гардан хариуцах
- Бусад санхүүжүүлэгч байгууллагаас НЦҮТ/ТХБ-ын байгуулах болоод үйл ажиллагаанд санхүүжилт авч байгаа, урьд нь авч байсан төвүүд ч мөн оролцох боломжтой.

D. Төслийн саналыг үнэлэх

НҮБХАС-гийн удирдлагаас томилсон үнэлгээний хороо доорх үнэлгээний хүснэгтийн дагуу төслийн саналуудыг дүгнэх болно.

Үнэлгээнд тавигдах шаардлага	Оноо
1. Байгууллагын чадамж	15
1.1. ЖСХ-ийн даван туулагчдад үйлчилгээ үзүүлж байсан тухай мэдээлэл, нотлох бүртгэл	5
1.2. ЖСХ/ГБХ-ийн холбогдолтой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байсан тухай мэдээлэл, нотлох баримт, тайлан, үр дүнгийн талаархи баримт мэдээлэл	5
1.3. Ирүүлсэн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хангалттай тооны, туршлагатай, мэргэжлийн ажилтнуудын талаархи мэдээлэл, баримт	5
2. Төслийн чанар	65
2.1. Дээр В хэсэгт дурдсан Төслийн зорилтуудыг хэрэгжүүлэх, тодорхой стратеги, төлөвлөгөө, арга зүйн талаар төслийн саналд хангалттай тусгасан байх	10
2.2. Төслийн саналын хүрэх үр дүн/зорилтууд дурдсан хугацаанд хэрэгжих боломжтой, тодорхой, дэлгэрэнгүй байх ба (1) цаашид тогтвортой хэрэгжихийн тулд нэмэлт санхүүжилт шаардахгүй байх, эсвэл (2) хэрэгжих үедээ орлого олох эх үүсвэртэй болох боломжтой байх	10

¹ ЖСХ-ийн хохирогч, даван туулагчдад үйлчилгээ үзүүлэх **Нэг цэгийн үйлчилгээний төв** нь аюулгүй байр, хамгаалал, хууль эрхзүй, нийгэм-сэтгэлзүй, эрүүл мэндийн зэрэг үйлчлүүлэгчдэд шууд хэрэгтэй нэн шаардлагатай үйлчилгээг нэг дороос үзүүлэх газар юм. Энгийн, шууд авах боломжтой үйлчилгээг төвд байх мэргэжилтнүүдээс авах боломжтой ба илүү нарийн мэргэжлийн үйлчилгээг НЦҮТ-өөс гадуур мэргэжилтнүүдээс авдаг.

² ЖСХ-ийн хохирогч, даван туулагчдад үйлчилгээ үзүүлэх **Түр хамгаалах байр** нь үйлчлүүлэгчдийг аюулгүй байранд байлгаж, бусад наад захын хэрэгцээг (хоол хүнс, хувцас гэх мэт) нь хангадаг бөгөөд бусад шаардлагатай үйлчилгээг гаднаас, холбон зуучилж авдаг.

2.3. Төслийн санал нь үйлчлүүлэгч эргэн хэвийн амьдралаа үргэлжлүүлэх ур чадвар болон санхүүгийн боломж, өөртөө итгэх итгэлтэй болоход туслах үйл ажиллагааг багтаасан байх, НЦҮТ/ТХБ-ны үйлчилгээг энэ чиглэлээр өргөжүүлэхэд чиглэсэн байх	15
2.4. НЦҮТ/ТХБ нь байраа хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон бусад эмзэг бүлгийн иргэдэд ээлтэй, хүртээмжтэй болгоход анхаарсан байх	15
2.5. Төслийн саналд тухайн орон нутгийн ЖСХ-ийн өнөөгийн нөхцөл байдлын талаар хангалттай мэдээлэл өгсөн байх, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа бусад байгууллага, хамтрагч талуудтай хамтран төслийн хүлээгдэж байгаа үр дүнд хүрэх, хэрэгжүүлэх боломжтой аргачлалыг тусгасан байх	10
2.6. Төслийн саналд хэрэгжүүлэх үйл ажиллагаануудыг тодорхой заасан байх ба тухайн үйл ажиллагаанууд төслийн зорилгод хүрэхэд хэрхэн холбогдож байгаа нь тодорхой байх	5
3. Орон нутгийн талаархи мэдээлэл	10
3.1. Төслийн зүгээс шийдвэрлэх боломжтой тухайн орон нутагт тулгамдаж байгаа асуудлууд, эсвэл төслийн хүрээнд хүрэхийг зорьсон үр дүнг илүү амжилттай хэрэгжүүлэхэд туслах нөөц боломж тухайн орон нутагт байгаа эсэх талаар мэдээлэлийг багтаах	5
3.2. Орон нутгийн засаг захиргааны чадавхи, ЖСХ-ийн чиглэлээр тууштай дэмжин ажиллаж ирсэн байдал, салбар дундын зохицуулалтын тогтолцоо бүтэц, бусад мэдээллүүдийг тодорхой багтаах	5
4. Төсвийн төлөвлөлт, үр ашиг, үр нөлөө	10
4.1. Төслийн саналд ирүүлсэн төсөв нь бодитой (хэмнэлттэй), санал болгож буй үйл ажиллагаануудаа хүрэлцэхүйц (үр ашигтай) бөгөөд эдгээр үйл ажиллагаагаар эерэг үр дүнд хүрэх (үр нөлөөтэй) боломжтой байх	10
НИЙТ ОНОО	100

Е. Төслийн саналыг хэрхэн ирүүлэх вэ?

Сонирхсон талууд доорх бичиг баримтуудыг Монгол эсвэл Англи хэл дээр 2021 оны 5-р сарын 25-ны оройн 6 цагаас өмнө procurement@unfpa.org.mn хаягаар имейлээр ирүүлнэ үү.

- Бүрэн бөглөсөн Өргөдлийн маягт (Өргөдлийг маягтыг НҮБХАС вэбсайтаас татаж авна уу)
- Төсвийн нарийвчилсан задаргаа
- Төслийг хэрэгжүүлэх нарийвчилсан хугацаа, энэ нь 2021 оны 6-р сарын 15-аас 2023 оны 5-р сарын 31-ны хооронд 2 жилийн хугацаатай байж болно.
- Улсын бүртгэлийн гэрчилгээ
- Аймаг, дүүргийн Засаг даргын зүгээс төслийг дэмжин ажиллахаа мэдэгдсэн албан захиа

Тогтсон хугацаанд дээрх баримт бичгүүдийг бүрэн ирүүлж чадаагүй газруудыг шаардлага хангаагүй гэж үзэж сонгон шалгаруулалтаас хасна.

Сонирхсон талуудад асууж, тодруулах зүйл байвал 2021 оны 5-р сарын 15-ны дотор batsuuri@unfpa.org имейл хаягаар бичгээр ирүүлнэ. НҮБХАС бичгээр ирүүлсэн хүсэлт,

тодруулгуудад өгсөн хариултуудыг нэгтгэн 2021 оны 5-р сарын 20-нд бүх сонирхсон оролцогч талуудад зориулан Монгол дахь НҮБХАС-ийн веб хуудаст байршуулна.

Сонгон шалгаруулах хугацаа нь доорх байдлаар явагдана:

- **2021 оны 5 сарын 25** – Материал хүлээж авах эцсийн хугацаа
- **2021 оны 5 сарын 26- 6 сарын 12** – Үнэлгээний хорооны сонгон шалгаруулах үйл явц
- **2021 оны 6 сарын 13** – Сонгогдсон газруудыг зарлаж,
- **2021 оны 6 сарын 15** – Санал болгосон төслийн хэрэгжилт эхлэнэ.

Монгол дахь НҮБХАС-ийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл <https://mongolia.unfpa.org> веб хуудаст зочилно уу.